

ЗҮҮН АЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ШИНЭ ТӨЛӨВ БА МОНГОЛ УЛС

*С.Отгонбаатар**

Өнөөдөр дэлхийн эдийн засгийн нээлттэй тогтолцоонд улс орнууд улам бүр татагдан орохын зэрэгцээ эдийн засгийн харилцан нөхсөн хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан худалдааны элдэв хориг саадыг арилгах замаар чөлөөт худалдааг хөгжүүлэхийг эрмэлзэх болсон нь эдийн засгийн интеграци өрнөх бодит нөхцөл болж байна. Энэхүү бүс нутгийн шинжтэй үйл явц нь тухайн бүс нутгийн орнуудын эдийн засгийн өсөлтийг түргэтгэхээс гадна хөгжлийн ирээдүйг нь тодорхойлох чухал хүчин зүйлийн нэг болжээ. Эдийн засгийн интеграцийн үйл явц бүс нутаг бүрт харилцан адилгүй түвшинд явагдаж байгаа ч Зүүн Азийн орнууд эдийн засгийн өсөлтийн хурдац, хөгжлийн ирээдүйн төлөв байдлаараа бусад бүс нутгуудаас илт ялгарах болсны зэрэгцээ хамтын ажиллагааны олон хэлбэрийн гэрээ байгуулагдан улс орнууд идэвхтэй нэгдэн орсоор байна. Зүүн Ази нь эдүгээ эрчимтэй өсөлт бүхий эдийн засгуудаас гадна хөгжлийн өөрийн өвөрмөц онцлогтой, дэлхийд тэргүүний технологи, санхүү, эдийн засгийн ихээхэн нөөц бололцоо бүхий Азийн шинээр аж үйлдвэржсэн орнууд, ASEAN-ний зарим орнуудыг багтааж байгаагаараа онцлог юм. Энэ утгаар нь авч үзвэл Зүүн Ази нь газар зүйн ойлголт гэхээсээ Ази, Номхон далайн бүс нутгийн салбар дэд бүсүүдийн /Зүүн болон Зүүн Өмнөд, Зүүн Хойд,/ орнуудаар эдийн засгийн хамрах хүрээгээ тодорхойлж буй эдийн засгийн орон зайн тухай ойлголт болжээ. Ийнхүү улс үндэстэн тэр ч байтугай бүс нутгийн газар зүйн тухай ойлголт эдийн засгийн хамрах хүрээгээр тодорхойлогдох болсон нь эдүгээ эрчимтэй өрнөж байгаа глобалчлалын үйл явцын бодит илрэл юм.

Зүүн Азийн эдийн засгийн эрчимтэй өсөлт, дэлхийн тэргүүлэх хөгжилтэй орнуудын түвшинд хүрэхүйц зарим орнуудын эдийн засгийн ололт амжилт нь Европын хөгжлийн 300 гаруй жилийн түүхийг 30 гаруй жилийн дотор бүтээж байгаагаараа онцлог бөгөөд үүнийг олон орны эдийн засагчид Зүүн Азийн гайхамшиг хэмээн нэрлэх болжээ. Тэгвэл энэ гайхамшигийг бүтээлцэж байгаа эдгээр орнуудын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, дэлхийн эдийн засагт эзлэх байр суурийг ДБ, ОУВС болон ОУ-ын эдийн засгийн бусад байгууллагуудаас хэрхэн тодорхойлж байгааг авч үзвэл:

* С.Отгонбаатар - МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль, доктор (Ph.D), дэд профессор

Зүүн Азийн орнуудын эдийн засгийн өсөлт /хувь/

Нэр/он	1999	2000	2001	2002
Япон	0,67	2,41	0,3	-0,6
БНХАУ	07,1	7,99	7,3	8
Гонконг	3,42	10,13	0,6	1,4
БНСУ	10,89	9,33	3,03	6
Тайвань	5,42	5,86	-2,18	3,2
Индонез	0,79	4,9	3,32	3,5
Малайз	6,14	8,33	0,43	4
Филлипин	3,4	4,38	3,22	4
Сингапур	6,93	10,25	-2,04	2,2
Тайланд	4,45	4,65	1,95	4,1
Вьетнам	4,77	6,76	6,84	6,5

Эх сурвалж.: www.icseed.org.jp

Зүүн Азийн энэхүү эдийн засгийн эрчимтэй өсөлт нь тухайн орнуудын засгийн газрын оновчтой бодлого түүний хэрэгжилтийн үр дүн бөгөөд ГШХО-г ихээр төвлөрүүлж, өндөр технологийн үйлдвэрлэл, ялангуяа экспортын чиглэлийн олон арван үйлдвэрүүд байгуулсантай холбон үзэх болсон билээ. Дэлхийн эдийн засагт багагүй нөлөөлсөн 1997, 2001 онд ажиглагдсан эдийн засгийн хямралууд энэ бүс нутгийг мөн тойрч гараагүй ч Зүүн Азийн орнууд олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцаатайгаар богинохон хугацаанд амжилттай даван гарч эдийн засгаа сэргээж чадсан юм. Тухайлбал, 2002 оны байдлаар Хятад, Солонгос, Вьетнам зэрэг орнуудын эдийн засгийн өсөлт нь харьцангуй өндөр болж 6-8 хувьд хүрсэн нь дэлхийн эдийн засагт өндөр үзүүлэлт байлаа.

**Зүүн Азийн орнуудын дэлхийн экспортод эзлэх хувь
/1997-2001 он/**

		1997	1998	1999	2000	2001	2002	2003
	Дэлхийн нийт	5575000	5490000	5700000	6430000	6155000	6272000	7443692
1	Япон	420957 7.6%	387927 7.1%	419936 7.4%	479249 7.5%	403496 6.6%	416700 6.6%	471817 6.3%
2	БНСУ	136164 2.4%	132313 2.4%	143686 2.5%	172286 2.7%	150439 2.4%	162500 2.5%	193817 2.7%
3	Сингапур	121985 2.2%	109895 2.0%	14680 0.3%	137804 2.1%	121751 2.0%	125200 1.9%	145366 2.0%
4	Тайвань	121081 2.2%	110518 2.0%	121496 2.1%	147777 2.3%	122505 2.0%	135100 2.1%	144180 2.2%
5	Тайланд	57374 1.0%	54456 1.0%	58440 1.0%	69057 1.1%	65113 1.1%	68900 1.1%	80522 1.1%
6	Индонези	53443 1.0%	48847 0.9%	48665 0.9%	62124 1.0%	56321 0.9%	57100 0.9%	62631 1.0%
7	Малайз	78740 1.4%	73305 1.3%	84455 1.5%	98135 1.5%	87921 1.4%	93300 1.5%	99369 1.3%
8	Филипин	24882 0.4%	29414 0.5%	36576 0.6%	39783 0.6%	32128 0.5%	36300 0.6%	36502 0.4%
9	Гонконг	188195 3.4%	174864 3.2%	174403 3.1%	202683 3.2%	191066 3.1%	201200 3.2%	223762 3.0%
10	Вьетнам	9185 0.2%	9361 0.2%	11540 0.2%	14448 0.2%	15093 0.2%	16500 0.3%	20176 0.3%
11	БНХАУ	182792 3.3%	183712 3.3%	194931 3.4%	249203 3.9%	266155 4.3%	325600 5.2%	437899 5.9%


Эх сурвалжийг Дэлхийн худалдааны байгууллагын
статистикийн эмхэтгэлээс 2003 он

Энэхүү эдийн засгийн өндөр өсөлт нь Зүүн Азийн орнуудын дэлхийн худалдаанд эзлэх байр суурийг тодорхойлж байгаа бөгөөд 2003 оны байдлаар эдгээр орнуудад дэлхийн экспортын 26.2 хувь, импортын 24.8 хувь ноогдох болсон юм.

Харин Зүүн Азийн орнуудын дотроос экспортын хэмжээ нь жил бүр тогтвортой өсөн нэмэгдэж байгаа орнуудад БНХАУ, БНСУ, Сингапур, Хятадын-Гонконгийг нэрлэж болно. Тухайлбал БНХАУ-ын эдийн засаг сүүлийн 10-аад жилд тогтвортой өсч жилийн дундаж өсөлт нь 7-10%-тай байв. Бүр дэлхийн худалдааны өсөлт ихээхэн буурсан үед ч БНХАУ-ын экспортын хэмжээ тогтмол өссөн үзүүлэлттэй байсныг эдийн засагчид онцлон үздэг. Тухайлбал 2000-2002 оны Хятадын гадаад худалдааны хэмжээ 30% өссөн бөгөөд худалдааны өсөлтийн хэмжээг дэлхийн нийт худалдааны өсөлттэй харьцуулахад 3 дахин илүү байв.

Диаграмм 5.1

Дэлхийн тэргүүлэх эдийн засагтай орнуудын гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх хувь, 2000, 2002 оныг харьцуулсан үзүүлэлт



International trade Statistics. WTO 2003

Энэхүү худалдааны эрчтэй өсөлт нь БНХАУ-ыг дэлхийн томоохон худалдааны түншлэгч болгож байгаа төдийгүй Европын Холбоог нэгдсэн зах зээлийнх нь хувьд худалдааны нэг л түнш гэж авч үзвэл БНХАУ дэлхийн худалдаанд тэргүүлэх эхний дөрвөн томоохон улсын нэг болж чадлаа.

Импортын хувьд тухайн бүс нутгийн томоохон зах зээл бүхий БНХАУ 1991 онд 1.8 хувьтай байсан бол 10 жилийн дараа буюу 2001 онд 3.8 хувийн өсөлттэй байв. Харин Япон улсын хувьд импортын өсөлт

1991 онд 6.8 хувь байсан бол 2001 онд 5.4 хувь болж буурсан нь тухайн улсын эдийн засагт бий болсон инфляцитай холбоотой гэж үзэж байна.

**Зүүн Азийн орнуудын дэлхийн импортод эзлэх хувь
/1997-2001 он/**

		1997	1998	1999	2000	2001	2002	2003
	Дэлхийн нийт	5727000	5670000	5912000	6711000	6441000	6534518	7614588
1	Япон	338754 5.9%	280484 4.9%	311262 5.3%	379511 5.7%	349089 5.4%	337194 5.1%	382930 5.0%
2	БНСУ	144616 2.5%	93282 1.6%	119752 2.0%	160481 2.4%	141098 2.2%	152126 2.3%	178827 2.3%
3	Сингапур	132437 2.3%	101732 1.8%	111060 1.9%	134545 2.0%	116000 1.8%	116441 1.8%	127934 1.7%
4	Тайвань	113924 2.0%	104946 1.9%	110957 1.9%	139927 2.1%	107274 1.7%	112758 1.8%	127249 1.7%
5	Тайланд	62854 1.1%	42971 0.8%	50342 0.9%	61924 0.9%	62058 1.0%	64658 1.0%	75809 1.0%
6	Индонез	41694 0.7%	27337 0.5%	24004 0.4%	33515 0.5%	30962 0.5%	25388 0.4%	41682 0.5%
7	Малайз	79030 1.4%	58314 1.0%	64966 1.1%	82199 1.2%	74079 1.2%	79869 1.2%	81948 1.0%
8	Филлипин	38622 0.7%	31496 0.6%	32568 0.6%	33008 0.5%	31358 0.5%	37180 0.5%	39502 0.5%
9	Гонконг	213297 3.7%	186759 3.3%	180711 3.1%	214042 3.2%	220082 3.0%	207644 3.1%	231896 3.0%
10	Вьетнам	11592 0.2%	11500 0.2%	11622 0.2%	15200 0.2%	15550 0.2%	16530 0.2%	20176 2.7%
11	БНХАУ	142370 2.5%	140237 2.5%	165699 2.8%	225094 3.4%	243553 3.7%	295171 4.5%	413062 5.4%

*Эх сурвалжийг дэлхийн худалдааны байгууллагын
статистикийн эмхэтгэлээс 2003 он*

Зүүн Ази дахь интеграцийн үйл явц, түүний онцлог

Өнөөдөр Зүүн Азид эдийн засгийн эрчимтэй өсөлтийг дагалдаад улс хооронд худалдаа, эдийн засгийн хоёр болон олон талт хамтын ажиллагааны шинэ шинэ хэлбэрийн гэрээ, хэлэлцээрүүд байгуулагдаж, чөлөөт бүсийг байгуулах замаар худалдааны элдэв хориг саадыг арилгах сонирхол идэвхтэй өрнөж байгаа нь тухайн орнуудын эдийн засгийн хөгжлийг түргэтгэх чухал хүчин зүйл болохын зэрэгцээ эдийн засгийн интеграцийг бодитойгоор эхлүүлэх нөхцөл болж байна.

Нөгөөтэйгүүр, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн харилцааг зохицуулах нэгдсэн бодлого, механизм бий болгох талаар бүс нутгийн орнууд ихээхэн идэвхитэй ажиллаж түүнд оролцох ОУ-ын байгууллагуудын үүрэг роль ч өсөн нэмэгдэх боллоо. Тухайлбал: НҮБ-ын Ази, Номхон далайн орнуудын эдийн засаг нийгмийн комисс /ESCAP/, Азийн Хөгжлийн Банк /ADB/, Засгийн газрын бус байгууллага болох Номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны

зөвлөл /РЕСС/ болон Номхон далайн орнуудын зөвлөл /САР/ зэргийг дурдаж болно.

Ийнхүү дэлхийн эдийн засгийн тогтвортой өсөлтийн нэг гол төв болсон Зүүн Азид эдийн засгийн интеграцийн бодит эхлэл тавигдаж буй өнөө үед бүс нутгийн интеграцийн үйл явцыг зохицуулах яриа хэлэлцээний шинэ шинэ механизмууд ч бий болсоор байна. Тухайлбал, энэ бүс нутгийн интеграцийн томоохон үйл явц болох АПЕС, ASEAN-ний нэр хүнд олон улсад өсөн нэмэгдэхийн зэрэгцээ ASEAN+3 /Хятад, Япон, Солонгос/, ASEAN+1 гэсэн томъёоллын хүрээнд /ASEAN+Хятад, ASEAN+Япон, ASEAN+ Солонгос, ASEAN+ОХУ, ASEAN+Энэтхэг.../ зэрэг хамтын ажиллагааны механизмууд амжилттай хөгжиж байгаа билээ. Мөн түүнчлэн сүүлийн жилүүдэд Зүүн Азийн орнууд дэлхийн худалдааны нэгдсэн системийн хүрээнд бүс нутагтаа төдийгүй дэлхийн бусад орнуудтай биеэ даан чөлөөт худалдааны хэлэлцээр /ЧХХ/ байгуулах хандлага ч нилээд түгээмэл боллоо. Чөлөөт худалдааны хоёр болон олон талт хэлэлцээрүүд нь орчин үед эдийн засгийн интеграцийг үүсгэх үндсэн нөхцөл болжээ. ЧХХ-үүд дэлхийн улс орнууд, бүс нутаг, эдийн засгийн бүлэглэлүүдийн хооронд байгуулагдах нь нилээд түгээмэл байна. Одоогоор ДХБ-ын мэдээгээр 100 гаруй ЧХХ байгуулагдан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. ЧХХ-ийн гол санаачлагч улс АНУ бөгөөд одоогийн байдлаар тус улс 10 гаруй оронтой ЧХХ байгуулаад байна. 2004 оны 5 сарын 6-нд АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш, Сингапурын ерөнхий сайд Го Чог Тон нар ЧХХ байгуулснаа зарласан нь АНУ-ын Ази дахь ЧХХ-ийн анхны хэлэлцээр болсон юм.

Ийнхүү ЧХХ-г амжилттай байгуулснаар улс орнууд хоёр талын уламжлалт харилцаандаа түшиглэн худалдааг улам өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж улам нэмэгдсээр байна.

Хүснэгт 1: Зүүн Азид Чөлөөт Худалдааны хэлэлцээр, түүний ахиц

Чөлөөт худалдааны хэлэлцээр	Хэлэлцээрийн үе шатууд				
	Санал солилцох шатанд	Хамтарсан судалгааны шатанд	Яриа хэлэлцээ явагдаж байгаа	Нэгдсэн дүгнэлтийн шатанд	Хэрэгжиж эхэлсэн
АФТА ¹					X
АФТА - Хятад			X		
АФТА - Япон		X			
АФТА - Солонгос		X			
АФТА- Энэтхэг	X				
АФТА - Америк	X				
АФТА - Япон - Солонгос	X				
Зүүн Азийн ЧХХ	X				
Япон - Чили		X			
Япон - Канад	X				
Япон - Мексик			X	X	
Япон - Тайвань	X				
Япон - Сингапур					X
Солонгос - Чили					X
Солонгос - Япон			X		
Солонгос - Мексик	X				
Солонгос - Шинэ Зеланд			X		
Солонгос - Сингапур			X		
Солонгос - Тайланд		X			

Эх сурвалж: *Inkyo Cheong "Korea's FTA Policy: Focusing on Bilateral FTAs discussion paper"*

Сүүлийн жилүүдэд Зүүн Азид эдийн засгийн түншлэлийн шинэ шинэ хэлбэрийн гэрээнүүд байгуулагдах боллоо. Эдгээр олон төрлийн хэлэлцээрүүд нь нэг ёсондоо олон улсын худалдаанд гишүүн орнуудын хооронд үүсэх тарифын болон тарифын бус элдэв хориг саадыг арилгах чиглэлтэй ЧХХ-ын эхлэл болж байгаа юм. Ийм хэлбэрийн гэрээнүүдэд мөн ГШХО болон эдийн засаг техникийн хамтын ажиллагааг тусгаж байна. Тухайлбал, 2002 оны 11-р сард Япон–Сингапурын хооронд байгуулагдсан Эдийн Засгийн Түншлэлийн гэрээ /JSEPA/ юм. Энэ нь Зүүн Азид өрнөж байгаа шинэ түншлэлийн гэрээний нэг хэлбэр юм. Тухайлбал: РТА /Partnership Trade Arrangement/ /Худалдааны түншлэлийн гэрээ/, РТА /Preferential Trade Agreement/ /Хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр/, CER /Closer Economic Relations/ /Эдийн засгийн нягт хамтын ажиллагаа/, NPA /New Partnership Agreement /Шинэ хэлбэрийн түншлэлийн хэлэлцээр/, FTA /Free Trade Agreement/ /Чөлөөт худалдааны хэлэлцээр/, RIA /Regional Integration Agreement/ /Бүсийн интеграцийн хэлэлцээр/.

Энэ бүс нутагт дээрхи олон төрлийн худалдааны гэрээ, хэлэлцээрүүд байгуулагдахад худалдааг либералчлах зорилгоор Америк, Европ амжилттай хэрэгжиж байгаа ЧХХ-үүд, тэдгээрийн үр дүн ихээхэн нөлөө үзүүлсэн гэж үзэж болно. Чөлөөт худалдааны хэлэлцээрүүд нь эдийн засгийн интеграцийн хүрээнд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхээс гадна улс төр, нийгмийн хүрээг ч өргөн хамарч, элсийн дүнд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болж байна. Олон улсын практикаас харахад чөлөөт худалдааны хэлэлцээрийг улс орнуудын харилцааны онцлог, цар хүрээнээс хамааруулан хэд хэдэн түвшинд хэрэгжүүлж байна.

Чөлөөт Худалдааны Хэлэлцээрүүд явагдаж байгаа түвшин:

- ◆ Bilateral Level /Хоёр талын/
- ◆ Regional Level /Бүс нутгийн/
- ◆ Global Level /Multilateral/ /Глобал түвшинд/

Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээн дэх Монгол Улс

Дэлхий дахин улам интеграцид орж глобалчлагдаж байгаа өнөө үед Монгол Улс дэлхийн бусад оронтой ямар харилцан хамааралтай байж ямар замаар улсаа хөгжүүлэх вэ? Гэдэг асуудал юунаас ч илүү чухал болж байна. Манай улсын хувьд АНД, түүний дотор ЗХА-ийн эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох нь чухал бөгөөд улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, эдийн засаг, нийгмийн хөгжил нь энэ бүс нутгийн цаашдын хөгжил, хамтын ажиллагаанаас ихээхэн хамааралтай билээ.

1992 – 2002 оны Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд

	нэгж	1995	1996	1997	1998	1999	2000	2001	2002
ДНБ	тэрбум ам.дол.	550.3	646.6	832.6	817.4	925.3	1044.6	1158.2	1231.3
Нэг хүн амд ноогдох ДНБ	ам.дол.	419	460	406	436	364	395	450	442
ДНБ-ний өсөлт	%	6.3	2.4	4.0	3.5	3.2	1.1	1.1	3.9
Инфляци	%	53.1	44.6	20.5	6.0	10.0	8.1	8.0	1.6
Экспорт	сая ам.дол.	473.3	424.3	451.5	345.2	358.3	535.8	521.5	524.0
Импорт	сая ам.дол.	415.3	450.9	468.3	503.3	512.8	614.5	637.7	690.8
Хүн ам	мян	2,317	2,353	2,387	2,421	2,374	2,408	2,443	2,480

Монгол Улс өөрөө цаашид хөгжихийн тулд аль нэг интеграцийн үйл явцад нэгдэн орох нь зайлшгүй бөгөөд манай улсын нэгэнт сонгон авсан ардчилал, зах зээлийн эдийн засгийн хөгжил нь интеграцийн процессгүйгээр хэрэгжихгүй гэдэг нь ойлгомжтой. Дэлхийн Худалдааны байгууллагын гишүүн орнуудын дунд эдийн засгийн интеграцийн ямар нэг гэрээ, хэлэлцээрт нэгдээгүй цөөхөн орны нэг нь Монгол Улс болоод байна. Иймээс улс орны нийгмийн байдал, дотооддоо авч хэрэгжүүлж байгаа шинэчлэлийн үйл явцтай уялдуулсан тодорхой төлөвлөгөө, интеграцийн загварыг боловсруулж тодорхой үе шаттайгаар авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Үүнд юуны өмнө:

1. Бүс нутгийн интеграцид нэгдэх шаардлага, үндэслэл
2. Өөрийн орны нөөц бололцоо, боломж
3. Чиглэл зорилго, хэрэгжүүлэх үе шат зэргийг тодорхойлж бүс нутгийн орнуудтай хоёр талын хамтын ажиллагааг бүхий л хэлбэрээр хөгжүүлж худалдааг өсгөж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хамтарсан объект байгуулахад ихээхэн анхаарах шаардлагатай.


Монгол Улсын хувьд харьцангуй буурай хөгжилтэй, үндэсний үйлдвэрлэл болон эдийн засгийн салбарын бүтэц хөгжөөгүй учир санхүү эдийн засаг, технологийн асуудлуудыг бие даан шийдвэрлэх боломжгүй юм. Иймд эдийн засгаа босгоход дэлхий нийтийн туршлагад тулгуурлан интеграцийн янз бүрийн хэлбэрийг ашиглах нь зохистой гэж бид үздэг. Үүнд:

- Таваарын солилцоо /бараа бүтээгдэхүүний худалдаа/
- Шууд хөрөнгө оруулалт, санхүүгийн капиталын зах зээлд гарах
- Үйлчилгээ /аялал жуулчлал, тээвэр харилцаа холбоо/
- Хөгжилтэй орнуудад ажиллах хүч гаргах
- Хамтарсан үйлдвэр байгуулах гэх мэт

Монгол Улс ЗХА-ийн орнуудтай 1990-ээд оноос худалдаа, эдийн засгийн болон нийгэм-улс төр, соёлын өргөн харилцааг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч ирлээ. Үүнд бүс нутгийн орнуудтай худалдаа нилээд өссөнийг дурьдаж болно. Мөн тус бүс нутгийн орнуудтай харилцаа, хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулсан нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал, Япон улстай “иж бүрэн түншлэл”-ийн, БНСУ-тай “харилцан нөхсөн хамтын ажиллагаа”, ОХУ, БНХАУ, БНАСАУ-уудтай “найрсаг харилцаа, хамтын ажиллагаа”-ны гэрээ байгуулсан. Монгол Улс бүс нутгийн харилцаа, хамтын ажиллагааг улам өргөжүүлэх үүднээс бүс нутгийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа дэд бүтцийг хөгжүүлэх томоохон төслүүдэд оролцохыг чухалчлан үзэж байна. Тухайлбал, ЗХА-ийн тээврийн нэгдсэн сүлжээний 9 коридороос 6-р маршрут буюу Москва-Улаанбаатар-Бээжин-Тянжины, 4-р маршрут буюу Монголын дорнод хэсгээс Түмэн голын сав газарт хүрэх чиглэлүүд нь Монголын нутгаар дайран өнгөрч байгаа ба энэ нь манай улсыг ЗХА-ийн болон

Төв Европын орнуудтай замын нэгдсэн сүлжээгээр холбогдох боломж бүрдүүлж байгаа юм. Москва-Бээжинг холбосон 6-р коридор нь Европ-Азийг холбосон хамгийн дөт зам бөгөөд түүний нийт урт нь 8016 км юм. Харин 4-р коридор нь Монголын Дорнод хэсгийг Жилинь муж (Хятад)-Түмэн голын бүстэй холбох бөгөөд үүгээр Монгол Улс далайд гарах бас нэг боломж байгаагаас гадна ирээдүйд Түмэн голын сав газрын эдийн засгийн бүсэд ажиллах боломж нээгдэх юм. ЗХА-ийн тээврийн нэгдсэн сүлжээ байгуулах энэхүү асуудал нь Монгол Улсын хувьд эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлнэ гэдэг үүднээс Монгол Улсын Засгийн газар ихээхэн ач холбогдол өгч байгаа билээ. Хэдийгээр өнөө үед ЗХА –ийн эдийн засгийн хамтын ажиллагааны үйл явц удаашралтай, цаашдын төлөв байдал нь ч төдийлөн тодорхой бус байгаа ч бүс нутгийн маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар бүсийн улс төр эдийн засгийн нөлөө бүхий орнууд, олон улсын байгууллагуудын оролцоотойгоор яриа хэлэлцээний бодит механизмыг бий болгох талаар идэвхтэй хамтран ажиллаж байгаа нь бодит үр дүнгээ өгнө гэдэгт найдаж байна. Харин Монгол улсын хувьд бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд өөрийн зүгээс бодит хувь нэмрээ оруулахаас гадна зарим талаар санаачлага гарган ажиллах нь зүйтэй санагдана. Үүний тулд ЗХА-ийн хамтын ажиллагааны цаашдын төлөв түүнд нөлөөлөх хүчин зүйлүүдийг сайтар судлахаас гадна бүс нутгийн орнуудтай хоёр талын харилцааг улам өргөжүүлж түншлэлийн шинэ хэлбэрийн гэрээнүүдэд нэгдэн орохыг зорих нь чухал байна. Мөн нөлөө бүхий олон улсын байгууллагууд бусад субъектүүдтэй идэвхтэй хамтран ажиллах нь чухал. Эдүгээ энэ бүс нутгийн хамтын ажиллагааны цар хүрээ улам өргөжиж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Иймээс эдгээр орнуудын хооронд худалдааг чөлөөлөх зорилгоор түншлэлийн олон хэлбэрийн гэрээнд нэгдэх хандлага давамгайлах төлөвтэй байна. Үүнтэй холбогдуулан Зүүн Хойд Азийн эдийн засгийн хамрах хүрээг Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Монгол, БНАСАУ зэрэг орнуудаас гадна түүнд нөлөө бүхий бусад субъектүүдийг ч хамааруулан авч үзэх нь зүйтэй юм.

The States and Non-states actors in the Northeast Asian



Энд бас нэг зүйлийг онцлон дурьдахад эдийн засгийн интеграцийн бүтэц хэлбэр ч цаашдаа шинэ шинэ хэлбэрээр баяжих боллоо. Тухайлбал эдийн засгийн глобалчлал эрчтэй өрнөх болсон өнөө үед интеграцийн үйл явц нь зөвхөн бүс нутгийн орнуудын хооронд биш, эдийн засгийн интеграцийн бүлэглэл хооронд яригдах боллоо. Тухайлбал, ЕХ-NAFTA-тай ТрансАтлантикийн холбоог үүсгэх тухай яригдаж байгаа бол, MERCOSUR-ЕХ ч хамтын ажиллагааны тухай хэлэлцэх болсон. Энэ бүхний бас нэг бодит жишээ бол Ази-Европын зөвлөлдөх уулзалт буюу АСЕМ юм. Ази-Европын дээд хэмжээний уулзалт хийх санаачлагыг 1994 онд Сингапурын ерөнхий сайд Го Чог Тонг Францад айлчлах үедээ гаргасан. АСЕМ нь Ази, Европын хамтын ажиллагааг харилцан хүндэтгэх, эрх тэгш хамтран ажиллах зарчмын үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлэх зорилготой бөгөөд одоогоор Бруней, БНХАУ, Индонези, БНСУ, Япон, Малайз, Филиппин, Вьетнам, Сингапур, Тайланд, Кампучи, Лаос, Бирма, ЕХ-25 улс нэгдэн ороод байна. Энэ бүх үйл явцыг эдийн засгийн интеграцийн боловсронгуй хэлбэр болох тив дамнасан интеграцийн эхлэл гэж хэлж болно.

Монгол Улс АНУ, БНСУ, Япон, Европын Холбооны гишүүн орнуудтай ЧХХ байгуулах асуудлаар судлаж байна. Эцэст нь дүгнэж хэлэхэд Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах, эдийн засгийн интеграцийн аль нэг гэрээнд нэгдэн орохын тулд юуны түрүүн интеграцийн бүтцийг дотооддоо бий болгох асуудал маш чухал болж байгаа юм. Үүний тулд үйлдвэрлэл капиталыг нэгтгэх замаар санхүүгийн капиталыг бий болгох нь чухал.

Зүүлт тайлбар

1. АФТА /AFTA/ - ASEAN –ны орнуудын Чөлөөт Худалдааны Бүс, 1992 онд Бруней, Индонез, Малайз, Филиппин, Сингапур, Тайланд зэрэг ASEAN-ны 6 орны хооронд байгуулагдсан ба хожим нь Камбож, Лаос, Бирма, Вьетнам нэгдэн орсон.